



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/59

Чойр


Төрийн захиргааны албан хаагчийн  
тангараг өргүүлж, төрийн жинхэнэ албан  
хаагч болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчийг тангараг өргүүлэх ёслолын журам", Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалт өгч тэнцэн, туршилтаар ажиллах хугацаандаа цаашид төрийн жинхэнэ албанд үр бүтээлтэй ажиллаж чадахаа нотлон харуулсан аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Дотоод ажил, өргөдөл гомдол, санал хүсэлт хариуцсан мэргэжилтэн Батдэлгэрийн Гарамсүрэн, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн Батмагнайн Нямцэрэн, Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн Жаргалсайханы Өлзийбаяр, Сүмбэр сумын 2 дугаар багийн нийгмийн ажилтан Гангантаяагийн Оюунболор, аймгийн Соёл, урлагийн газрын Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Лхагвасүрэнгийн Энхчимэг, Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Хишигдоржийн Буянтогтох, Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн Баасандоржийн Лхагвамаа, аймгийн Мал эмнэлгийн газрын Өвчний мэдээ, тайлан, цахим бүртгэл, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Очирын Пүрэвсамбуу, Зооноз, халдварт өвчин тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Цогбаярын Сувд, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын даамал Зоригтбаатарын Туяа, Газрын даамал Төмөрбаатарын Өлзийбуд, аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын мэргэжилтэн Мягмарын Байгалмаа нарыг төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлсүгэй.

2.Өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, Монгол Улсын хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахиж, албан үүргээ хариуцлагатай үнэнч шударгаар биелүүлж, төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, албан үүргээ хариуцлагатай үнэнч шударгаар биелүүлж, төрийн жинхэнэ албан хаагчийн нэр хүнийг өндөрт өргөж ажиллахыг тангараг өргөсөн төрийн албан хаагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

Б. доргуусан: *Д. Доржиев*  
Химчиг: *С. Доржиев*  
Хуга: *2*